

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/400/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2025 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
Тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: А.Цогбаяр
Утас: 315558 Цахим хаяг: tsogbayara@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Ариунжаргал
Утас: 261740 Цахим хаяг: ariunjargalb@audit.gov.mn
Аудитор: Г.Өсөхжаргал
Утас: 261740 Цахим хаяг: Usukhjargalq@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА З.ЭНХБОЛД ТАНАА

2025.02.25 № 07/748
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар дараах материаллаг хэмжээний зөрчлүүд илэрлээ. Тухайлбал:

- Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор нийт 59,152.2 мянган төгрөгийн хөрөнгө дутагдсаныг авлагаар бүртгээгүй, буруутай албан тушаалтныг тогтоогоогүй;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу, гэрээ дүгнэсэн актгүй, хийсэн ажлын үр дүнгийн тайлангүй зэрэг нийт 57,370.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг хүлээн зөвшөөрч бүртгэлд тусгасан;
- Тайланд хугацаанд зарцуулсан нийт 17,249.7 мянган төгрөгийн шатахууны тооцоог хийгээгүй, зарцуулалтыг тайлагнаагүй байхад зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн;
- Удирдлагын тушаал шийдвэр, Өмч хамгаалах зөвлөл болон техникийн комиссын дүгнэлтгүйгээр үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй авто тээврийн хэрэгсэлд 15,000.0 мянган төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн;
- Шүүхийн шийдвэрээр эргэж ажилдаа орсон албан хаагчийн нөхөн олговорт цалингийн нэмэгдэл зардлаас 60,490.4 мянган төгрөгийг олгосон зэрэг

Z:\Yawsan_Bichig\2025\0225 SNAG-72.Docx

1525070286

зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна.

Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.5, 13.7, 19 дүгээр зүйлийн 19.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1, 72 дугаар зүйлийн 72.3, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.6, 15.2.3, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 101 дүгээр зүйлийн 101.1, 104 дүгээр зүйлийн 104.1, 134 дүгээр зүйлийн 134.1 дэх заалтуудтай тус тус нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлангийн “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Нэмэлт санхүүжилтийн дансаар Олон улсын хөдөлмөрийн байгууллагатай байгуулсан PO40477315 дугаартай гэрээний дагуу “Байгалийн гамшгийн хор уршгийг арилгах нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлэх” төслийн хүрээнд 35,000.0 мянган төгрөгийн санхүүжилтийн орлого бүрдүүлж, Өмнөговь аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 24,000.0 мянган төгрөг, Хэнтий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт 11,000.0 мянган төгрөгийг олгож байгалийн гамшгийн хор уршгийг арилгах, нөхөн сэргээх ажилд тус тус зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар нь тайлант онд хураамжийн төлбөрөөс 355,494.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлснээс солонгос хэлний түвшин тогтоох шалгалт зохион байгуулах заалны түрээсийн зардалд 10,600.0 мянган төгрөг, бичиг хэрэг, шалгалтын материал тээвэрлэлтийн зардалд 19,558.0 мянган төгрөг, томилолтын зардалд 25,804.4 мянган төгрөг, мэдээлэл технологи, онлайн үйлчилгээний зардалд 18,273.5 мянган төгрөг, шалгалтад хянагчаар ажилласан гэрээт ажилчдын ажлын хөлсөд 112,210.1 мянган төгрөгийг зарцуулсан. Мөн шалгалтад тэнцсэн 294 иргэдэд шалгалтын дараах сургалт зохион байгуулах болон сургалттай холбоотой бусад зардалд 59,670.9 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Төслийн хэрэгжилтийг дэмжих ажлын хүрээнд Гэр бүл, Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 08 дугаар сарын 26-ны өдрийн “Хуваарь батлах тухай” А/09 дүгээр тушаалаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт 74,633.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг олгосон байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь “ejob” платформ хэрэглэгчдийн ажиллах орчин нөхцөлийг сайжруулах зорилгоор улсын төсвийн хөрөнгөөр урсгал засвар хийж нийт 18,851.3 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	364,571,570.23	220,144,717.61
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	5,376,859.53	21,019,770.55
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	5,376,859.53	21,019,770.55
3121	Төгрөг	1,750,000.00	16,005,000.00
31218	Ахмадын сангийн харилцах	1,750,000.00	16,005,000.00
3122	Гадаад валют	3,626,859.53	5,014,770.55
31223	Арилжааны банк дахь харилцах	3,626,859.53	5,014,770.55
33	АВЛАГА	34,336,032.96	16,709,854.13
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	244,028.00	564,117.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	21,187,455.33	484,000.00
335	Бусад авлага	12,904,549.63	15,661,737.13
33510	Байгууллагаас авах авлага	-	2,757,187.50
33520	Хувь хүмүүсээс авах авлага	12,904,549.63	12,904,549.63
34	УРЬДЧИЛГАА	-	14,468,133.60
34600	Урьдчилж гарсан зардал	-	14,468,133.60
35	БАРАА МАТЕРИАЛ	324,858,677.74	167,946,959.33
354	Хангамжийн материал	324,858,677.74	167,946,959.33
35410	Бичиг хэргийн материал	5,919,736.00	11,645,926.00
35420	Аж ахуйн материал	25,069,686.00	23,244,796.00
35430	Сэлбэг хэрэгсэл	24,959,200.00	24,371,700.00
35470	Бусад хангамжийн материал	268,910,055.74	108,684,537.33
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,368,029,811.79	7,448,274,528.09
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,368,029,811.79	7,448,274,528.09
392	Биет хөрөнгө	5,474,335,003.66	5,303,027,129.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	5,478,292,733.00	5,478,292,733.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(533,583,269.40)	(640,299,923.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	117,918,700.00	117,918,700.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(76,193,993.00)	(86,847,109.64)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	4,393,806,458.28	4,599,245,664.28
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,913,163,257.49)	(4,210,684,066.10)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	382,545,587.52	424,664,223.52
39208	Хуримтлагдсан элэгдэл	(378,884,280.21)	(381,660,642.23)
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,795,100.00	4,795,100.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,198,775.04)	(2,397,550.08)
393	Биет бус хөрөнгө	2,893,694,808.13	2,145,247,398.62
39301	Программ хангамж	5,457,194,227.90	5,457,194,227.90
39302	Хуримтлагдсан элэгдэл	(2,587,266,339.77)	(3,335,713,749.28)
39303	Бусад биет бус хөрөнгө	303,025,080.00	303,025,080.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(279,258,160.00)	(279,258,160.00)

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	8,732,601,382.02	7,668,419,245.70
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	23,454,557.96	13,388,549.63
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	23,454,557.96	13,388,549.63
413	Өглөг	23,454,557.96	13,388,549.63
4136	Бусад өглөг	23,454,557.96	13,388,549.63
41361	Байгууллагад төлөх өглөг	10,550,008.33	484,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	12,904,549.63	12,904,549.63
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,709,146,824.06	7,655,030,696.07
51	Засгийн газрын хувь оролцоо	8,709,146,824.06	7,655,030,696.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	23,766,920.00	23,766,920.00
51101	Өмч: - төрийн	23,766,920.00	23,766,920.00
512	Хуримтлагдсан үр дүн	6,598,452,303.51	5,544,336,175.52
51210	Өмнөх үеийн үр дүн	5,317,109,950.48	6,598,832,203.51
51220	Тайлант үеийн үр дүн	1,281,342,353.03	(1,054,496,027.99)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,086,927,600.55	2,086,927,600.55
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН V	8,732,601,382.02	7,668,419,245.70

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	8,661,048,091.36	7,124,692,080.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,139,253,479.36	3,299,196,085.50
120	Нийтлэг татварын бус орлого	5,139,253,479.36	3,299,196,085.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,926,091,560.92	3,071,637,743.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,914,692,743.76	3,044,716,588.99
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,398,817.16	26,921,154.51
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,210,700,918.44	227,558,342.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,521,794,612.00	3,825,495,995.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,480,886,533.00	3,738,834,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,480,886,533.00	3,738,834,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,040,908,079.00	86,661,895.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,040,908,079.00	35,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	51,661,895.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	7,136,637,926.30	8,166,454,905.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	7,136,637,926.30	8,166,454,905.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,201,931,995.47	4,840,071,456.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,599,099,255.44	2,191,596,456.03
210101	Үндсэн цалин	907,710,520.08	1,189,121,358.80
210102	Нэмэгдэл	300,095,616.19	541,707,888.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	211,467,613.52	294,579,998.58
210104	Урамшуулал	176,671,164.05	166,187,210.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	202,204,621.99	270,593,929.71
210201	Тэтгэврийн даатгал	141,106,899.59	185,745,044.10
210202	Тэтгэмжийн даатгал	15,241,670.54	21,512,300.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,381,342.54	11,398,686.74
210204	Ажилгүйдлийн даатгал	3,447,516.10	9,968,755.94
210205	Эрүүл мэндийн даатгал	30,027,193.22	41,969,142.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145,924,230.28	169,469,204.58
210301	Гэрэл, цахилгаан	103,442,401.32	116,713,716.45
210302	Түлш, халаалт	25,290,443.79	28,672,796.85
210303	Цэвэр, бохир ус	11,351,385.17	13,482,691.28
210304	Байрны түрээс	5,840,000.00	10,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	400,897,638.73	237,671,737.28
210401	Бичиг хэрэг	87,485,050.00	28,836,750.00
210402	Тээвэр, шатахуун	255,080,734.00	24,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,377,301.73	31,345,145.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,040,000.00	2,520,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,914,553.00	31,620,566.00
210408	Бараа материал акталсны зардал	-	119,349,275.60

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2105	Нормативт зардал	-	4,230,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	4,230,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	32,325,100.00	74,611,872.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,683,300.00	10,616,046.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	23,049,500.00
210604	Урсгал засвар	29,641,800.00	40,946,326.00
2107	Томилолт, зочны зардал	135,095,080.30	91,043,976.00
210702	Дотоод албан томилолт	131,634,980.30	85,043,976.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,460,100.00	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	784,197,172.21	482,774,527.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	746,865,009.21	440,550,658.30
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,627,108.00	282,451.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	29,345,250.00	41,244,556.00
210807	Газрын төлбөр	1,736,095.00	146,862.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,327,400.00	550,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,902,188,896.52	1,318,079,753.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,146,220.07	112,359,172.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	166,287,592.00	38,027,555.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,715,755,084.45	1,167,693,025.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,934,705,930.83	3,326,383,448.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	116,992,537.00	58,134,633.34
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	9,845,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	77,228,304.00	48,289,633.34
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,817,713,393.83	3,268,248,815.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	99,392,852.85	516,026,113.90
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	1,675,298.02	1,028,612.66
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	1,716,645,242.96	2,751,194,088.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>1,524,410,165.06</u>	<u>(1,041,762,824.50)</u>
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	243,067,812.03	12,733,203.49
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	3,563,491.03	1,433,243.49
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	-	11,299,960.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(243,067,812.03)	(12,733,203.49)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>1,281,342,353.03</u>	<u>(1,054,496,027.99)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,766,920.00	2,086,927,600.55	5,324,798,837.06	7,435,493,357.61
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(7,688,886.58)	(7,688,886.58)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,766,920.00	2,086,927,600.55	5,317,109,950.48	7,427,804,471.03
Тайлант үеийн үр дүн	-	-	1,281,342,353.03	1,281,342,353.03
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,766,920.00	2,086,927,600.55	6,598,452,303.51	8,709,146,824.06
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	379,900.00	379,900.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	23,766,920.00	2,086,927,600.55	6,598,832,203.51	8,709,526,724.06
Тайлант үеийн үр дүн	-	-	(1,054,496,027.99)	(1,054,496,027.99)
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	23,766,920.00	2,086,927,600.55	5,544,336,175.52	7,655,030,696.07

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,458,436,181.25	6,908,255,185.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,936,641,569.25	3,072,121,743.50
120	Нийтлэг татварын бус орлого	1,936,641,569.25	3,072,121,743.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,936,641,569.25	3,072,121,743.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,925,242,752.09	3,045,200,588.99
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,398,817.16	26,921,154.51
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,521,794,612.00	3,836,133,442.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,480,886,533.00	3,738,834,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,480,886,533.00	3,738,834,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,040,908,079.00	97,299,342.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	1,040,908,079.00	35,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	62,299,342.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,427,847,564.11	6,871,179,530.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,427,847,564.11	6,871,179,530.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,471,954,177.95	3,544,312,082.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,599,099,255.47	2,206,064,589.63
210101	Үндсэн цалин	907,710,520.08	1,189,121,360.03
210102	Нэмэгдэл	300,095,616.19	556,176,020.90
210103	Унаа хоолны хөнгөлөлт	211,467,613.55	294,579,998.58
210104	Урамшуулал	176,671,164.05	166,187,210.12
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	202,204,621.96	270,593,929.71
210201	Тэтгэврийн даатгал	141,106,899.59	185,745,044.10
210202	Тэтгэмжийн даатгал	15,241,670.54	21,512,300.73
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,381,342.54	11,398,686.74
210204	Ажилгүйдлийн даатгал	3,447,516.10	9,968,755.94
210205	Эрүүл мэндийн даатгал	30,027,193.19	41,969,142.20
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	145,924,230.28	172,226,392.08
210301	Гэрэл, цахилгаан	103,442,401.32	116,713,716.45
210302	Түлш, халаалт	25,290,443.79	31,429,984.35
210303	Цэвэр, бохир ус	11,351,385.17	13,482,691.28
210304	Байрны түрээс	5,840,000.00	10,600,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	397,474,325.73	136,407,131.68
210401	Бичиг хэрэг	84,483,950.00	34,042,950.00
210402	Тээвэр, шатахуун	255,080,734.00	24,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,377,301.73	31,345,145.68
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,040,000.00	2,520,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,492,340.00	44,499,036.00
2105	Нормативд зардал	-	4,230,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	4,230,000.00

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	38,721,900.00	102,478,292.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,080,100.00	33,477,966.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	27,249,500.00
210604	Урсгал засвар	29,641,800.00	41,750,826.00
2107	Томилолт, зочны зардал	135,095,080.30	91,043,976.00
210702	Дотоод албан томилолт	131,634,980.30	85,043,976.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	3,460,100.00	6,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	784,197,172.21	493,740,216.30
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	746,865,009.21	448,316,347.30
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,627,108.00	282,451.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	29,345,250.00	41,244,556.00
210807	Газрын төлбөр	1,736,095.00	146,862.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	4,327,400.00	3,750,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	169,237,592.00	67,527,555.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,950,000.00	29,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	166,287,592.00	38,027,555.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,955,893,386.16	3,326,867,448.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	116,992,537.00	58,134,633.34
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	9,845,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	77,228,304.00	48,289,633.34
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,838,900,849.16	3,268,732,815.25
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	109,942,861.18	516,510,113.90
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	12,312,745.02	1,028,612.66
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	1,716,645,242.96	2,751,194,088.69
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	30,588,617.14	37,075,654.51
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	25,439,999.98	19,999,500.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,439,999.98	19,999,500.00
2200	Дотоод эх үүсвэрээр	25,439,999.98	19,999,500.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	25,439,999.98	19,999,500.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(25,439,999.98)	(19,999,500.00)
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал	0.00	1,433,243.49
250001	Гадаад валютын ханшийн зөрүү		1,433,243.49
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	0.00	(1,433,243.49)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,148,617.16	15,642,911.02
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	3,791,733.40	5,376,859.53
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,376,859.53	21,019,770.55

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,021,934,100.00	3,516,330,486.40	505,603,613.60	87.43
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,021,934,100.00	3,516,330,486.40	505,603,613.60	87.43
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,021,934,100.00	3,516,330,486.40	505,603,613.60	87.43
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,595,611,100.00	2,206,064,589.63	389,546,510.37	84.99
210101	Үндсэн цалин	1,205,872,300.00	1,189,121,360.03	16,750,939.97	98.61
210102	Нэмэгдэл	888,640,900.00	556,176,020.90	332,464,879.10	62.59
210103	Унаа хоолны хөнгөлөлт	356,976,000.00	294,579,998.58	62,396,001.42	82.52
210104	Урамшуулал	144,121,900.00	166,187,210.12	(22,065,310.12)	115.31
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	365,133,300.00	270,593,929.71	94,539,370.29	74.11
210201	Тэтгэврийн даатгал	248,290,700.00	185,745,044.10	62,545,655.90	74.81
210202	Тэтгэмжийн даатгал	29,210,600.00	21,512,300.73	7,698,299.27	73.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,605,300.00	11,398,686.74	3,206,613.26	78.04
210204	Ажилгүйдлийн даатгал	14,605,300.00	9,968,755.94	4,636,544.06	68.25
210205	Эрүүл мэндийн даатгал	58,421,400.00	41,969,142.20	16,452,257.80	71.84
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	172,311,100.00	172,226,392.08	84,707.92	99.95
210301	Гэрэл, цахилгаан	116,715,100.00	116,713,716.45	1,383.55	100.00
210302	Түлш, халаалт	31,457,000.00	31,429,984.35	27,015.65	99.91
210303	Цэвэр, бохир ус	13,539,000.00	13,482,691.28	56,308.72	99.58
210304	Байрны түрээс	10,600,000.00	10,600,000.00	-	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	111,145,600.00	109,396,035.68	1,749,564.32	98.43
210401	Бичиг хэрэг	34,648,000.00	34,042,950.00	605,050.00	98.25
210402	Тээвэр, шатахуун	5,051,200.00	5,000,000.00	51,200.00	98.99
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	32,357,800.00	31,345,145.68	1,012,654.32	96.87
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,590,900.00	2,520,000.00	70,900.00	97.26
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	36,497,700.00	36,487,940.00	9,760.00	99.97
2105	Нормативд зардал	5,000,000.00	4,230,000.00	770,000.00	84.60
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	5,000,000.00	4,230,000.00	770,000.00	84.60
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	93,293,300.00	92,677,792.00	615,508.00	99.34
210601	Багаж, техник, хэрэгсэл	36,459,400.00	36,227,466.00	231,934.00	99.36
210602	Тавилга	2,250,000.00	2,250,000.00	-	100.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	11,892,000.00	12,449,500.00	(557,500.00)	104.69
210604	Урсгал засвар	42,691,900.00	41,750,826.00	941,074.00	97.80
2107	Томилолт, зочны зардал	87,171,600.00	81,233,976.00	5,937,624.00	93.19
210702	Дотоод албан томилолт	81,171,600.00	75,233,976.00	5,937,624.00	92.69

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	6,000,000.00	6,000,000.00	-	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	505,301,000.00	493,740,216.30	11,560,783.70	97.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	454,527,600.00	448,316,347.30	6,211,252.70	98.63
210803	Даатгалын үйлчилгээ	2,280,400.00	-	2,280,400.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	542,000.00	282,451.00	259,549.00	52.11
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	198,000.00	-	198,000.00	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	42,987,300.00	41,244,556.00	1,742,744.00	95.95
210807	Газрын төлбөр	269,300.00	146,862.00	122,438.00	54.53
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	733,200.00	-	733,200.00	-
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,763,200.00	3,750,000.00	13,200.00	99.65
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	68,232,200.00	67,527,555.00	704,645.00	98.97
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	29,500,000.00	29,500,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	38,732,200.00	38,027,555.00	704,645.00	98.18
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,734,900.00	18,640,000.00	94,900.00	99.49
2132	Бусад урсгал шилжүүлэг	18,734,900.00	18,640,000.00	94,900.00	99.49
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,734,900.00	18,640,000.00	94,900.00	99.49
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,021,934,100.00	3,531,173,902.50	490,760,198.30	95.14
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,738,834,100.00	3,237,651,401.75	501,182,698.25	86.60
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,738,834,100.00	3,237,651,401.75	501,182,698.25	86.60
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	283,100,000.00	293,522,500.30	(10,422,500.00)	103.68
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	283,100,000.00	293,522,500.30	(10,422,500.00)	103.68
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1	1	-	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	72	72	-	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	60	60	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	11	11	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		97,299,342.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		97,299,342.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		66,621,096.00
2104	Хангамж, бараа материалын зардал		27,011,096.00
210402	Тээвэр, шатахуун		19,000,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		8,011,096.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		29,800,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		15,000,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		14,800,000.00
2107	Томилолт, зочны зардал		9,810,000.00
210702	Дотоод албан томилолт		9,810,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		30,678,246.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		29,649,633.34
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		29,649,633.34
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,028,612.66
213303	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг		1,028,612.66
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		97,299,342.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		97,299,342.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж		35,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		62,299,342.00

3. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 479.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 139.9 сая төгрөгийн алдааг залруулж, 4.6 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 225.7 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлж, 109.0 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

3.1. Аудитаар санхүүгийн тайлагналтай холбоотой 139.9 сая төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа илрүүлж, аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруул-аагүй		Тоо	Дүн
							тоо	Дүн	тоо	Дүн		
2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Мөнгөн гүйлгээний тайланд тусгасан төвлөрүүлэх шилжүүлгийн тооцоо нийлсэн актаас 484.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	484.0					1	484.0				
Харилцагч байгууллагад тооцоо нийлсэн актаар 2,757.2 мянган төгрөгийн авлагатай гарсныг баталгаажуулсан боловч санхүүгийн тайланд авлагаар тайлагнаагүй.	1	2,757.2					1	2,757.2				
Шүүхийн шийдвэрээр ажилдаа буцаж орсон албан хаагчтай холбоотой гарсан урьдчилж гарсан зардлын 14,468.1 мянган төгрөгийг НДШ-ийн авлагаар бүртгэж тайлагнасан.	1	14,468.1					1	14,468.1				
Үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнг санхүүгийн үр дүнгийн тайлангийн үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын дүнгээс 25,327.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан.	1	25,327.0					1	25,327.0				

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд бүртгэлтэй авлагын Капитал банкнаас 36,550.0 мянган төгрөгийн үнэ бүхий авто тээврийн хэрэгслээр барагдуулсан авлагыг ТӨБЗГ-ын баталсан 2024 оны 08 дугаар тогтоолоор ХЭДС-ын эргэлтийн хөрөнгийн худалдан	1	36,550.0					1	36,550.0				
борлуулах зориулалттай үндсэн хөрөнгө дансанд бүртгэж, нээлттэй дуудлагын худалдаагаар худалдан борлуулж, орлогыг ХЭДС-д төвлөрүүлэхээр заасан байхад ХХҮЕГ үндсэн хөрөнгөд орлогоор бүртгэсэн.												
Тайлант онд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 2 ширхэг үндсэн хөрөнгөд 997.4 мянган төгрөгийн элэгдлийг илүү байгуулсан байна.	1	997.4					1	997.4				
Мөнгөн гүйлгээний тайланд тээвэр шатахууны зардлыг 20,000.0 мянган төгрөгөөр, хөдөлмөр хамгааллын зардлыг 15,000.0 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 21,000.0 төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан.	1	57,000.0					1	57,000.0				
Үндсэн үйл ажиллагааны орлого 1,177.4 мянган төгрөгийг мөнгөн гүйлгээний тайлангаас цэвэрлэж тайлагнасан.	1	1,177.4					1	1,177.4				
Үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлангийн 1300 нэр төрлийн 424,092.4 мянган төгрөгийн тавилга, эд хогшлыг жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогын дүнгээс 1,073.0 мянган төгрөгөөр илүү илэрхийлсэн байна	1	1,073.0					1	1,073.0				
Дүн	9	139,834.0	-	-	-	-	9	139,834.0	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

3.2. Аудитаар нийт 283.8 сая төгрөгийн зөрчил² илэрснээс, 4.6 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 178.2 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 101.0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Зөрчлийн дүн		Үүнээс:							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор 38 ширхэг нийт 59,152.2 мянган төгрөгийн таблет дутагдсаныг авлагаар бүртгээгүй, буруутай албан тушаалтныг тогтоогоогүй байна.	1	59,152.1			1	59,152.1				
Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар "Хязгаарлалттай" дүгнэлт авсан санхүүгийн 3 албан хаагчид 4,581.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон.	1	4,581.0	1	4,581.0						
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 1 авто тээврийн хэрэгсэлд тушаал шийдвэр, Өмч хамгаалах зөвлөл болон техникийн комиссын дүгнэлтгүй нийт 15,000.0 мянган төгрөгийн засвар үйлчилгээ хийсэн байна.	1	15,000.0			1	15,000.0				
Бараа материалын тайланд 2021 онд зохион байгуулагдсан "Оролцоо төсөл"-тэй холбоотой хэрэгцээ шаардлагагүй 19,430 ширхэг 43,439.8 мянган төгрөгийн бараа материалыг их хэмжээгээр нөөцөлснийг Өмч хамгаалах зөвлөлийн болон хөрөнгийн тооллогын комиссын шийдвэргүй бараа материалын данснаас хасалт хийсэн, уг бараа материал нь агуулахад биетээр оршин байна.	1	43,439.8			1	43,439.8				

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын /хуучин нэрээр/ 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 01/333 тоот албан бичгийг хэрэгжүүлэхдээ нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулаагүй, Сангийн сайдын А/229 дүгээр тушаалаар баталсан журмыг шууд хуулбарлан 2024 оны 12 дугаар сарын 23-нд аж ахуйн нэгжтэй ажил гүйцэтгүүлэх гэрээ байгуулж, нэг бүр нь 128.00 мянган төгрөгийн үнэтэй 150 ширхэг нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг хэвлүүлэн хэвлэлийн зардалд нийт 19,200.0 мянган төгрөгийг олгосноос үйл ажиллагааны төсвөөс 3,200.0 мянган төгрөгийг зарцуулж, төсвийг үрэлгэн зарцуулсан байна	1	3,200.0			1	3,200.0				
Анхан шатны баримтын бүрдэл дутуу, гэрээ дүгнэсэн актгүй, хийсэн ажлын үр дүнгийн тайлан гаргаагүй, анхан шатны баримтаар нотлогдохгүй нийт 18 гүйлгээний 57,370.3 мянган төгрөгийн ажил гүйлгээг бүртгэлд тусгасан байна.	1	57,370.3			1	57,370.3				
Тайлант онд "Ахмадын сан"-ийн 16,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир усны зардлаас бүрдүүлсэн байна.	1	16,000.0					1	16,000.0		
Тайланд хугацаанд зарцуулсан нийт 17,249.7 мянган төгрөгийн шатахууны тооцоог хийгээгүй, зарцуулалтыг тайлагнаагүй байхад зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	1	17,249.7					1	17,249.7		
Шүүхийн шийдвэрээр эргэж ажилдаа орсон албан хаагчийн цалинд цалингийн нэмэгдэл зардлаас 60,490.4 мянган төгрөгийг олгосон боловч авлагаар бүртгээгүй байна.	1	60,490.4					1	60,490.4		
Байгууллагын хамтын сан бүрдүүлэх зорилгоор Хөдөлмөрийн дотоод журамд заагаагүй хуримтлалд албан хаагчдын цалингаас сар бүр 10.0 мянган төгрөг буюу нийт 7,310.0 мянган төгрөгийг суутган санхүү хариуцсан мэргэжилтний харилцах дансанд төвлөрүүлсэн байна.	1	7,310.0					1	7,310.0		
Дүн	10	283,793.5	1	4,581.0	5	178,162.4	4	101,050.1	-	-

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

3.3.Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар 55.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 47.5 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 8.0 сая төгрөгийн зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн утга	Зөрчлийн дүн		Үүнээс:							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил										
Шилэн дансны цахим хуудсанд 183 мэдээлэл байршуулахаас 10 мэдээллийг хугацаа хоцроон байршуулж, 5 сая төгрөгөөс дээш дүнтэй зарлагын 8,032.5 мянган төгрөгийн 1 гүйлгээний мэдээллийг байршуулаагүй байна.	1	8,032.5					1	8,032.5		
Дүн	1	8,032.5					1	8,032.5		
Өмнөх оны аудитаар өгсөн үндсэн хөрөнгийн дансанд цаашид ашиглах боломжгүй нийт 13 төрлийн 2,023,090.8 мянган төгрөгийн бүртгэлтэй программ хангамжийг шийдвэрлэх талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	-			1	-				
Өмнөх аудитаар өгсөн төрд учруулсан хохирлыг буруутай албан тушаалтнаар нөхөн төлүүлэх хувь хүмүүсээс авах 12,904.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар талаар өгөгдсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй байна.	1	12,904.5			1	12,904.5				

БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллах хүч гаргах, үндсэн чиглэлийн үйл ажиллагаа, зохион байгуулахад нийт 15 иргэнийг хөлсөөр ажиллуулах гэрээ байгуулж, цалингийн зардалд 34,563.4 мянган төгрөгийг холбогдох журамд тусгагдсан зардлаас зориулалт бусаар зарцуулсан байна.	1	34,563.4			1	34,563.4				
Үндсэн хөрөнгийн дансанд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үлдэх өртөггүй 5,621,096.7 мянган төгрөгийн 3,212 ширхэг хөрөнгөд дахин үнэлгээ хийгдээгүй, тайлант онд цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг шийдвэрлэх зорилгоор Өмч хамгаалах зөвлөл 3 удаа байгуулагдсан боловч тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй байна.	1	-			1	-				
Дүн	4	47,467.9	-	-	4	47,467.9				
НИЙТ ДҮН	5	55,500.4	-	-	4	47,467.9	1	8,032.5		